



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/021-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-3047 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	15-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15-16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	16-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-18
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	21-25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	26-27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНАУТХ	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ЦЭНГЭЛСАЙХАН ТАНАА

2025.02.21 № СЭА-2025/021/ХА-СТА-ТМ.3
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй, хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, ашиглалтад оршиж буй зөрчил материаллаг буюу өргөн хүрээгээр тархсан байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6-д заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Албан томилолтын зардалтай давхардуулан **1,156.8** мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон,
- Төсвийн **4,858.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,

432502019³

- Төсвийн хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтээр хэрэгжсэн 927,435.4 мянган төгрөгийн өртөг бүхий 6 төсөл, хөтөлбөрөөр нийлүүлсэн хөрөнгүүдийн ашиглагчидтай гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, ашиглалт, зарцуулалт, бүртгэл, тайлагналд нь хяналт хэрэгжүүлээгүй, хуваарилалтын мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжид ил тод, нээлттэй хүргээгүй, авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд 17 сум, 6 тосгоны малчдад сургалт, уулзалт зохион байгуулах, мэдээлэл түгээх үйл ажиллагааг зохион байгуулж, албан томилолтын зардалд 33,560.0 мянган төгрөг, шатахууны зардалд 15,000.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үүний үр дүнд 378 хоршоо шинээр байгуулагдаж, 850 малчин өрхийг зээлд хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Төсөл, хөтөлбөрөөр хэрэгжсэн арвай, овъёосны үрийг хугацаа алдаж хуваарилж, тарааснаас гэрээний хугацаанд эргэн төлөлт бүрэн хийгдээгүй, авлагаар тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 20 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 88.8 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	209,960,605.55	823,811,007.18
33	АВЛАГА	39,440,331.57	69,412,921.38
33300	Татаас санхүүжилтийн авлага	1,027,970.00	0.00
33500	Бусад авлага	38,412,361.57	69,412,921.38
33510	Байгууллагаас авах авлага	24,722,472.56	42,820,743.89
33520	Хувь хүмүүсээс авах авлага	13,689,889.01	32,592,177.49
35	БАРАА МАТЕРИАЛ	170,520,273.98	754,398,085.80
35100	Түүхий эд материал	6,764,553.98	575,926,905.80
35110	Тусгай зориулалттай материал	6,764,553.98	575,926,905.80
35400	Хангамжийн материал	163,755,720.00	156,471,180.00
35410	Бичиг хэргийн материал	2,858,680.00	2,766,580.00
35420	Аж ахуйн материал	931,000.00	808,000.00
35440	Түлш, шатах тослох материал	15,136,640.00	1,145,000.00
35470	Бусад хангамжийн материал	144,829,400.00	151,751,600.00
35600	Мал амьтад	0.00	16,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	588,989,064.01	683,246,467.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	588,989,064.01	683,246,467.64
39200	Биет хөрөнгө	584,021,064.01	408,267,967.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	198,695,396.80	198,695,396.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,372,937.68	-55,581,935.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,650,000.00	176,650,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-159,616,666.78	-169,275,000.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	263,908,480.65	271,678,480.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,183,037.56	-201,919,644.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,836,333.77	28,836,333.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,508,530.32	25,786,336.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	399,393,990.09	399,393,990.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	-108,781,964.96	214,423,316.95
39300	Биет бус хөрөнгө	4,968,000.00	274,978,500.00
39301	Программ хангамж	6,800,000.00	6,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,800,000.00	6,800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,968,000.00	274,978,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	798,949,669.56	1,507,057,474.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,691,582.39	15,691,582.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,691,582.39	15,691,582.39
41300	Өглөг	15,691,582.39	15,691,582.39
41360	Бусад өглөг	15,691,582.39	15,691,582.39
41361	Байгууллагад төлөх өглөг	15,691,582.39	15,691,582.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	783,258,087.17	1,491,365,892.43
51	Засгийн газрын хувь оролцоо	783,258,087.17	1,491,365,892.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	806,717,089.41	1,076,727,589.41
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	806,717,089.41	1,076,727,589.41
51200	Хуримтлагдсан үр дүн	-108,885,570.52	329,211,734.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-632,574,454.14	-108,885,570.52
51220	Тайлант үеийн үр дүн	523,688,883.62	438,097,305.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,426,568.28	85,426,568.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	798,949,669.56	1,507,057,474.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,875,773,645.35	2,532,904,436.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,105,160,535.35	1,228,404,319.25
120	Нийтлэг татварын бус орлого	1,105,160,535.35	1,228,404,319.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,105,160,535.35	1,228,404,319.25
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	456,069,365.35	229,166.62
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	649,091,170.00	1,228,175,152.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	770,613,110.00	1,304,500,117.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	715,742,400.00	1,081,710,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	715,742,400.00	1,081,710,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,870,710.00	222,789,417.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,955,400.00	220,943,337.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,915,310.00	1,846,080.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	945,870,625.73	1,613,468,235.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,870,625.73	1,613,468,235.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,724,533.90	1,358,960,191.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,408,081.42	702,355,689.65
210101	Үндсэн цалин	307,092,506.31	388,077,241.45
210102	Нэмэгдэл	115,637,711.64	236,752,890.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,873,911.45	22,693,611.40
210104	Урамшуулал	38,803,952.02	54,831,946.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,164,948.29	88,586,267.64
210201	Тэтгэврийн даатгал	41,381,800.00	61,186,428.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,727,300.00	7,211,890.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,955.36	3,651,044.02
210204	Ажилгүйдлийн даатгал	919,308.38	3,309,781.08
210205	Эрүүл мэндийн даатгал	9,362,584.55	13,227,124.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,334,299.89	21,261,439.48
210301	Гэрэл, цахилгаан	1,667,493.89	1,782,000.48
210302	Түлш, халаалт	14,969,066.00	17,973,649.00
210303	Цэвэр, бохир ус	1,697,740.00	1,505,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,869,541.39	75,348,650.00
210401	Бичиг хэрэг	4,279,320.00	4,700,600.00
210402	Тээвэр, шатахуун	28,920,250.00	64,718,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,218,321.39	2,452,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,451,650.00	3,477,300.00
2105	Нормативт зардал	0.00	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	9,770,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,080,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	6,690,100.00
2107	Томилолт, зочны зардал	32,025,600.00	72,800,200.00
210702	Дотоод албан томилолт	32,025,600.00	72,800,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,480,172.00	77,768,810.20

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,241,600.00	66,242,317.20
210803	Даатгалын үйлчилгээ	2,955,700.00	2,899,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,000.00	324,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,700.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,740,000.00	7,926,000.00
210807	Газрын төлбөр	150,172.00	222,833.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,441,890.91	310,819,034.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,843,000.00	127,616,772.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,634,750.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,964,140.91	183,202,262.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,146,091.83	254,508,043.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	97,914,905.97
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	7,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	8,411,185.97
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	81,678,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	425,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,646,091.83	156,593,137.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,049,175.01	21,954,953.65
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	89,596,916.82	134,638,183.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	929,903,019.62	919,436,201.26
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	406,214,136.00	481,338,896.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	406,214,136.00	481,338,896.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	523,688,883.62	438,097,305.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	859,872,776.82	1,451,056,432.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	859,872,776.82	1,451,056,432.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	715,742,400.00	1,081,710,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	715,742,400.00	1,081,710,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,130,376.82	369,345,732.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,955,400.00	220,943,337.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,915,310.00	2,874,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,259,666.82	145,528,345.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	859,047,776.82	1,443,836,432.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	859,047,776.82	1,443,836,432.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,873,714.99	1,189,328,388.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,408,081.42	702,355,689.65
210101	Үндсэн цалин	307,092,506.31	388,077,241.45
210102	Нэмэгдэл	115,637,711.64	236,752,890.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,873,911.45	22,693,611.40
210104	Урамшуулал	38,803,952.02	54,831,946.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,164,948.29	88,586,267.64
210201	Тэтгэврийн даатгал	41,381,800.00	61,186,428.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,727,300.00	7,211,890.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,955.36	3,651,044.02
210204	Ажилгүйдлийн даатгал	919,308.38	3,309,781.08
210205	Эрүүл мэндийн даатгал	9,362,584.55	13,227,124.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,408,301.89	21,261,439.48
210301	Гэрэл, цахилгаан	1,667,493.89	1,782,000.48
210302	Түлш, халаалт	17,043,068.00	17,973,649.00
210303	Цэвэр, бохир ус	1,697,740.00	1,505,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,243,861.39	60,851,410.00
210401	Бичиг хэрэг	5,273,000.00	4,277,000.00
210402	Тээвэр, шатахуун	42,776,890.00	49,581,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,218,321.39	2,452,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,975,650.00	4,540,300.00
2105	Нормативт зардал	115,000.00	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,000.00	250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	15,481,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	7,591,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	7,890,100.00
2107	Томилолт, зочны зардал	32,025,600.00	72,800,200.00
210702	Дотоод албан томилолт	32,025,600.00	72,800,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,030,172.00	100,125,510.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,791,600.00	88,599,017.20
210803	Даатгалын үйлчилгээ	2,955,700.00	2,899,500.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,000.00	324,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,700.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,740,000.00	7,926,000.00
210807	Газрын төлбөр	150,172.00	222,833.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,477,750.00	127,616,772.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,843,000.00	127,616,772.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,634,750.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,174,061.83	254,508,043.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	97,914,905.97
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	7,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	8,411,185.97
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	81,678,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	425,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,674,061.83	156,593,137.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,049,175.01	21,954,953.65
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	90,624,886.82	134,638,183.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	825,000.00	7,220,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	825,000.00	7,220,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	825,000.00	7,220,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	825,000.00	7,220,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	825,000.00	7,220,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	825,000.00	7,220,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-632,574,454.14	259,569,203.55
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
5	Тайлант үеийн үр дүн	0	0	523,688,883.62	523,688,883.62
6	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-108,885,570.52	783,258,087.17
7	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-108,885,570.52	783,258,087.17
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	270,010,500.00	0	0	270,010,500.00
11	Тайлант үеийн үр дүн			438,097,305.26	438,097,305.26
12	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,076,727,589.41	85,426,568.28	329,211,734.74	1,491,365,892.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,081,710,700.00	1,059,755,746.35	21,954,953.65	98.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,081,710,700.00	1,059,755,746.35	21,954,953.65	98.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,073,700.00	963,840,840.38	17,232,859.62	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	637,364,900.00	635,544,774.74	1,820,125.26	99.7
210101	Үндсэн цалин	402,081,800.00	388,077,241.45	14,004,558.55	96.5
210102	Нэмэгдэл	201,299,800.00	169,941,975.59	31,357,824.41	84.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,373,600.00	22,693,611.40	10,679,988.60	68.0
210104	Урамшуулал	609,700.00	54,831,946.30	(54,222,246.30)	8.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,545,500.00	80,213,123.16	1,332,376.84	98.4
210201	Тэтгэврийн даатгал	55,451,000.00	55,507,500.45	(56,500.45)	100.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,523,500.00	6,543,780.85	(20,280.85)	100.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,261,800.00	3,295,209.42	(33,409.42)	101.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,261,800.00	2,975,726.48	286,073.52	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,047,400.00	11,890,905.96	1,156,494.04	91.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,501,800.00	21,261,439.48	2,240,360.52	90.5
210301	Гэрэл, цахилгаан	3,757,300.00	1,782,000.48	1,975,299.52	47.4
210302	Түлш, халаалт	18,148,800.00	17,973,649.00	175,151.00	99.0
210303	Цэвэр, бохир ус	1,595,700.00	1,505,790.00	89,910.00	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	57,325,300.00	57,318,560.00	6,740.00	100.0
210401	Бичиг хэрэг	3,281,200.00	4,277,000.00	(995,800.00)	130.3
210402	Тээвэр, шатахуун	47,156,000.00	47,154,030.00	1,970.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,827,400.00	2,452,230.00	375,170.00	86.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,060,700.00	3,435,300.00	625,400.00	84.6
2105	Нормативт зардал	279,500.00	250,000.00	29,500.00	89.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	279,500.00	250,000.00	29,500.00	89.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,152,100.00	22,701,100.00	451,000.00	98.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,152,100.00	14,811,000.00	341,100.00	97.7
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,890,100.00	109,900.00	98.6
2107	Томилолт, зочны зардал	72,056,600.00	71,920,200.00	136,400.00	99.8
210702	Дотоод албан томилолт	72,056,600.00	71,920,200.00	136,400.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,848,000.00	74,631,643.00	11,216,357.00	86.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,602,000.00	63,105,150.00	10,496,850.00	85.7
210803	Даатгалын үйлчилгээ	2,899,500.00	2,899,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	646,700.00	324,160.00	322,540.00	50.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	154,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,220,000.00	7,926,000.00	294,000.00	96.4

210807	Газрын төлбөр	325,800.00	222,833.00	102,967.00	68.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,637,000.00	95,914,905.97	4,722,094.03	95.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,637,000.00	95,914,905.97	4,722,094.03	95.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	5,400,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,274,900.00	8,411,185.97	863,714.03	90.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	85,398,200.00	81,678,720.00	3,719,480.00	95.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	563,900.00	425,000.00	138,900.00	75.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,081,710,700.00	1,081,710,700.00	-	100.0
12200	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,081,710,700.00	1,081,710,700.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	1,081,710,700.00	1,081,710,700.00	-	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	28.00	28.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.00	27.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	369,345.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,345.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,707.54
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	66,810.91
210102	Нэмэгдэл	66,810.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,373.14
210201	Тэтгэврийн даатгал	5,678.93
210202	Тэтгэмжийн даатгал	668.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	355.83
210204	Ажилгүйдлийн даатгал	334.05
210205	Эрүүл мэндийн даатгал	1,336.22
2104	Хангамж, бараа материалын зардал	3,532.85
210402	Тээвэр, шатахуун	2,427.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,105.00
2107	Томилолт, зочны зардал	880.00
210702	Дотоод албан томилолт	880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	25,493.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	25,493.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,616.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,616.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,638.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	134,638.18
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэг шилжүүлэг	134,638.18
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	369,345.73
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	220,943.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,874.05
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	145,528.35

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид Хүнс, хөдөө аж ахуйн газар гэх/ нь "Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэний сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- "Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль 2024 онд батлагдсан гэх мэт.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ХХААХҮС-ын ХШҮДАГ-аас дотоод хяналт тавьдаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХААХҮС-ын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 дүгээр тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 708,107.8 мянган төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	39,440.3	75,412.9	35,972.6
Бараа материал	170,520.3	748,398.1	577,877.8
Үндсэн хөрөнгө	588,989.1	683,246.5	94,257.4
Нийт хөрөнгө	798,949.7	1,507,057.5	708,107.8
Өр төлбөр	15,691.6	15,691.6	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	783,258.1	1,491,365.9	708,107.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	798,949.7	1,507,057.5	708,107.8

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 35,972.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 75,412.9 мянган төгрөг болсон нь аж ахуйн нэгж, иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон хүнсний ногоо, арвай, овъёосны үрийн төлбөр төлөгдөөгүйгээс болон 6,000.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн 20 толгой үржлийн ухна стандартын шаардлагад нийцэлгүйгээр буцааснаас шалтгаалсан,
- Бараа материалын дансны үлдэгдэл 577,877.8 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-аас 63,000.0 мянган төгрөгийн зуны хүлэмж, 499,103.0 мянган төгрөгийн тариалангийн талбай хамгаалах зориулалттай төмөр

бетон шонг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр нийт 16,000.0 мянган төгрөгийн үржлийн хуц худалдан авч, үлдэгдлээр тайлагнасан зэргээс шалтгаалсан байна.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 94,257.4 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-аас 550.0 мянган төгрөгийн суурин компьютерыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, байгууллагын эзэмшилд буй 3 газрыг нийт 270,010.5 мянган төгрөгөөр үнэлж, бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 7,220.0 мянган төгрөгийн камер, суурин компьютер, сканер зэргийг тус тус худалдан авсан болон элэгдлийн зардлын өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг **1,065,929.4** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 173,679.9 мянган төгрөгөөр бууруулж, **892,249.5** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 15,640.5 мянган төгрөгөөр,
- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 10,531.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол
- Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 65,000.0 мянган төгрөгөөр,
- Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 42,600.0 мянган төгрөгөөр,
- Мэргэжлийн хяналтын хөтөлбөрийн зардлыг 35,750.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 23,742.2 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 14,309.4 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 189,461.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **1,081,710.7** мянган төгрөг болгон тодотгол, зохицуулалт хийж, эцэслэн баталсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой зардлыг 11,300.0 мянган төгрөгөөр,
- Хангамжийн материалын зардлыг 42,598.2 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 18,000.0 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 41,650.0 мянган төгрөгөөр,
- НДШ-ийн зардлыг 1,875.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 166.4 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тэтгэмжийн зардлыг 67,798.2 мянган төгрөгөөр,

- Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 44,350.0 мянган төгрөгөөр,
- Мэргэжлийн хяналтын хөтөлбөрийн зардлыг 916.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол
- Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 31,600.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 3,798.2 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,794.4 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,081,710.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,059,755.8 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн төсөв 11,216.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Мэргэжлийн хяналт	916.0	916.0	0.0	100.0
2	Мал аж ахуйг хөгжүүлэх	44,350.0	38,350.0	6,000.0	86.5
3	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	17,450.0	13,660.2	3,789.8	78.3
4	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, үндсэн үйл ажиллагаа	918,357.7	910,914.7	7,443.0	99.2
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж / арга хэмжээ /	100,637.0	95,914.9	4,722.1	95.3
	Дүн	1,081,710.7	1,059,755.8	21,954.9	98.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130019401 тоот дансанд нийт 369,345.7 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгжээс хөнгөлөлттэй үнээр олгосон эргэн төлөгдөх хүнсний ногоо, арвай, овьёосны үрийн авлагын 145,528.3 мянган төгрөг,
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас зээл авсан аж ахуйн нэгж болон иргэдийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхэд зориулан шатахуун, албан томилолтын зардалд 1,846.1 мянган төгрөг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс шагналын 2,000.0 мянган төгрөг, ургацын баярын болон алтан намрын арга хэмжээг зохион байгуулахад зориулан 40,573.0 мянган төгрөг, аймгийн аюулгүйн нөөцийн тэжээл бүрдүүлэхэд 102,092.3 мянган төгрөг,
- Аймгийн санхүүгийн дэмжлэгээс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 76,278.1 мянган төгрөг гэх мэт.

Үүнээс 234,707.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, хүнсний ногоо, арвай, овъёосны үрийн болон төсвийн хэмнэлтийн нийт 134,638.2 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 945,870.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **9,458.7** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хөрөнгөд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө болох 1,507,057.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **15,070.6** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрээр явуулж, бичиг хэрэг, шуудан холбооны батлагдсан төсвийг 346.0 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд хэмнэлтийн горим хэрэгжүүлж, 2,240.3 мянган төгрөгийн төсвийг хэмнэсэн,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг 5 автомашинд төрийн албаны цэнхэр дугаарыг хэрэглэж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 171 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тайлангийн зарлагын баримт, шаардах хуудсанд дарга, нягтлан бодогчийн болон жолоочийн тооцооны хуудсыг албан хаагчдын гарын үсгээр баталгаажуулаагүй зэргийг нөхөн зуруулж, анхан шатны бүрдэл дутуу баримтуудыг нөхөн бүрдүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,187.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7,736.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 23,783.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,187.9	1	1,187.9	100.0
Албан шаардлага	3	7,736.2	3	7,736.2	100.0
Зөвлөмж	4	23,783.7	4	23,783.7	100.0
Нийт дүн	8	32,707.8	7	32,707.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ✓ ХХААХҮЯ-наас хүнсний үйлдвэрлэл /17450.0 мянган төгрөгийн/ болон мал аж ахуйг хөгжүүлэх /44,350.0 мянган төгрөгийн/ хөтөлбөрүүдийн зардлыг “Бусад нийтлэг АҮТХураамж” зардалд бөөн дүнгээр баталж, хэрэгжүүлсэн байгаа нь төсвийн гүйцэтгэлийг арга хэмжээ, эдийн засгийн ангилал, зардлын зүйлээр хянах төрийн сангийн хяналтыг сулруулж байна.
- ✓ “Даталанд Технологи” ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-г байгуулж, 2024 оны программ хангамжийн үйлчилгээний төлбөрт 7,200.0 мянган төгрөгийг төлсөн байна. /2023 оноос ашиглаж эхэлсэн буюу 2024-2025 оны төсвийн төслийг боловсруулсан байна/

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **96,392.3** мянган төгрөгийн дараах алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- ✓ Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан нийт 90,392.3 мянган төгрөгийн малын тэжээл, хивгийг шууд зардлаар тайлагнасныг бараа материалын дансаар дамжуулах бичилтийг хийлгэсэн,
- ✓ Хүлээн аваагүй нийт 6,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 20 толгой ухныг бараа материалд орлого авч, тайлагнасныг авлагаар тусгуулсан гэх мэт.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт **936,208.1** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **1,156.8** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **932,293.4** мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэн, **2,757.9** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд албан томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлт **1,156.8** мянган төгрөг тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

5.2.1. Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас тээврийн хэрэгслийн даатгалын зардалд **2,100.5** мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд **2,557.5** мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардалд **200.0** мянган төгрөг зэрэг нийт **4,858.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Төсвийн хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтээр хэрэгжсэн дараах **927,435.4** мянган төгрөгийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, ашиглалт, зарцуулалт, бүртгэл, тайлагналд нь хяналт хэрэгжүүлээгүй, холбогдох мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжид ил тод, нээлттэй мэдээлээгүй, авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зэрэг нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, үр нөлөөг бууруулж байгаагаас гадна ашиг сонирхлын зөрчил үүсэх, улмаар төсвийн эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дэх “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...”, 20.2.6 дахь “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх “төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах” гэсэн заалтуудыг тус тус зэрчсэн байна.

1. 2023 оны 11 дүгээр сард ХХААХҮЯ-наас тус газарт хүлээлгэн өгч, бүртгэл, тайланд тусгуулсан /Шаамар суманд 2023 онд суурилуулсан/ нийт **224,835.2** мянган төгрөгийн 30 ширхэг хүлэмжийг цахилгаан, усалгаа зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдээгүй гэх үндэслэлээр огт ашиглаагүй нь нар, салхинд элэгдэх, хөрөнгө үрэгдэх, үнэгүйдэх эрсдэлийг үүсгэж байна.

2. 2024 онд 10 дугаар сард ХХААХҮЯ-аас тус газарт үнэ төлбөргүйгээр хуваарилсан нийт **63,000.0** мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг хүлэмжийг нөхцөл шаардлага /эргэн төлөгдөх, эсвэл үнэ төлбөргүйгээр эзэмшилд нь бүр мөсөн өгсөн эсэх нь тодорхой бус/-ыг тусгасан гэрээ байгуулаагүй, мэдээллийг иргэд, хэрэглэгчдэд ил тод, нээлттэй мэдээлэлгүйгээр 8 сумын 10 иргэнийг сонгон авч, хүлээлгэн өгсөн байна.

3. ХХААХҮС-ын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар тушаалаар төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан 3 үүлдрийн бог малын хээлтүүлэгч төвлөрүүлэх зардлын санхүүжилт 28,000.0 мянган төгрөгийг аймгийн ХХААГ-т шилжүүлснийг дараах 2 аж ахуйн нэгж, иргэнтэй шууд гэрээ байгуулж, нийт 22,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийн, тус газрын хөрөнгөд орлого авч, 6,000.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуй ОНӨААТҮГ-т 20 хуц авахаар 8,000.0 мянган төгрөг,
- Ерөө сумын Буман Ерөө хонь үржлийн ХХК-иас 20 хуц авахаар 8,000.0 мянган төгрөг,
- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын иргэн Ц.Оюун-эрдэнэд 20 ухна авахаар 6,000.0 мянган төгрөг гэх мэт.

Дээрх 2 аж ахуйн нэгжээс худалдан авсан **16,000.0** мянган төгрөгийн өртөг бүхий 40 толгой хуцыг “Буман ерөө хоршоо” үржлийн нэгжид /уг аж ахуйн нэгжээс өөрөөс 20 толгой хуц худалдан авч, буцаагаад өөрт нь хүлээлгэн өгсөн гэх/ хүлээлгэн өгсөн гэх боловч энэ нь нөхцөл шаардлагыг тусгасан гэрээ, хүлээлгэн өгсөн акт, жилийн эцсийн мал тооллогын “А” данс зэрэг анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Харин иргэн Ц.Оюун-Эрдэнээс худалдан авсан 20 толгой ухна нь стандартын шаардлага

хангахгүй гэж буцаан санхүүгийн тайланд 6,000.0 мянган төгрөгийн авлага нэмж, тайлагнасан байна.

4. ХХААХҮС-ын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/678 дугаар тушаалаар тариалангийн талбайг хашаажуулахад зориулан нийт **499,103.0** мянган төгрөгийн өртөг бүхий 18,700 ширхэг /нэг бүрийн үнэ 26690 төгрөг/ төмөр бетон шонг тус газарт хүлээлгэн өгснийг *"Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд төмөр бетон шон шилжүүлэх"* гэрээ 15 жил ашиглуулаад үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгөхөөр гэрээнд тусгасан/ байгуулан дараах 12 аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгч, тус газрын хөрөнгийн бүртгэлд тайлагнасан байна. Үүнд:

- Баянгол сумын Баян шинэ зам ХХК /8,540.8 мянган төгрөгийн үнэ бүхий 320 ширхэг/
- Зүүнбүрэн сумын Энх хос мөрөн ХХК /32,028.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1200 ширхэг/, Газар агро ХХК /38,967.4 мянган төгрөгийн өртөг бүхий 1460 ширхэг/,
- Жавхлант сумын Сонжин агро ХХК /26,690.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1000 ширхэг/,
- Орхон сумын ЗДТГ /төмс, хүнсний ногоо тариалдаг иргэдэд 79,002.4 мянган төгрөгийн үнэ бүхий 2960 ширхэг/,
- Орхонтуул сумын Орхон тариа ХХК /40,035.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1500 ширхэг/,
- Хушаат сумын Голын өндөр ХХК /106,760.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4000 ширхэг/, Ар сэвд могойт ХХК /23,487.2 мянган төгрөгийн үнэ бүхий 880 ширхэг/, Өгөөж мандал уул ХХК /61,920.8 мянган төгрөгийн үнэ бүхий 2320 ширхэг/,
- Цагааннуур сумын Атар трейд ХХК /14,946.4 мянган төгрөгийн үнэ бүхий 560 ширхэг/, Товхонхан ХХК /26,690.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1000 ширхэг/, Сэлэнгэ тариа ХХК /40,035.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1500 ширхэг/.

Гэвч өндөр өртөг бүхий бетонон шонг хуваарилах "Ажлын хэсэг" байгуулаагүй бөгөөд төрөөс хэрэгжүүлж буй дээрх хөтөлбөрийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжид нээлттэй мэдээлээгүй, хуваарилалтыг ямар шалгуурыг үндэслэн хэрхэн зохион байгуулсан нь тодорхой бус байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

5. 2021 онд ХХААХҮЯ-аас тус газарт үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн **108,805.6** мянган төгрөгийн өртөг бүхий дараах тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч иргэн, аж ахуйн нэгжид 3 жилийн хугацаанд ашиглуулахаар гэрээ байгуулж, дараах байдлаар хуваарилан, тус газрын хөрөнгийн бүртгэлд тусгасан байна. Үүнд:

- 20ш усалгааны зөөврийн усан санг 10 сумын 19 иргэнд,
- 10 ширхэг хүлэмжийг 4 сумын 10 иргэнд гэх мэт,

Гэвч гэрээ байгуулснаас хойш тоног төхөөрөмжүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд огт хяналт хийгээгүй, байгуулсан гэрээ 2024 онд дууссан

атал эдгээр хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, тус байгууллагын хөрөнгийн бүртгэлд анхны өртгөөрөө бүртгэлтэй байна.

6. 2021 онд үүссэн бөгөөд иргэдээс авч Хөдөө аж ахуйг дэмжих санд төлөх **15,691.6** мянган төгрөгийн хүнсний ногооны үрийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Цалин, хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас албан хаагчдын 7 дугаар сарын цалинг зөрүүтэй тооцож, 6 албан хаагчид **2,097.9** мянган төгрөгийн цалин дутуу олгосон нь өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дэх *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээ, төлбөр тооцоог тухай бүр хянаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

5.3.2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Ёс зүйн хорооны хийсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэл, зарцуулсан цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр Ёс зүйн хорооны гишүүн М.Чинбаярт **660.0** мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

Өгсөн зөвлөмж: Хийсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэл, зарцуулсан цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр Ёс зүйн хорооны гишүүдэд цалин, урамшуулал олгож, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Загруулсан		Загруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хүлээж аваагүй хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан	1	6,000.0			1	6,000.0	1	6,000.0				
Хивэг, тэжээлийг бараа материалын дансаар дамжуулалгүйгээр шууд зарлагдсан	1	90,392.3	1	90,392.3			1	90,392.3				
Нийт дүн	2	96,392.3	1	90,392.3	1	6,000.0	2	96,392.3				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилогтын хоолны зардлыг хоолны хөнгөлөлттэй давхардуулан олгосон	1	1,156.8	1	1,156.8								
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	4,858.0			1	4,858.0						
Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, ашиглалт, зарцуулалтад хяналт тавиагүй, мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлээгүй, авлага, өр төлбөрийг хянаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй	6	927,435.4			6	927,435.4						
Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэх эрсдэл үүсгэсэн.	1	2,097.9					1	2,097.9				
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	660.0					1	660.0				

/мянган төгрөгөөр/

